

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 03 дугаар сарын 27-ны өдөр

№ 23/16

Улаанбаатар хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 76.2 дахь хэсэг, 80 дугаар зүйлийн 80.4, 80.7 дахь хэсэг, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.20 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 20.5 дахь хэсэг болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн эцнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн зээлийн үйл ажиллагаанд шаардлагатай эх үүсвэрийг төвлөрүүлэх зорилгоор “АНД Дэнсүл” ХХК болон “АНД Алтернатив Финанс” ХХК-тай хамтран ажиллахаар шийдвэрлэсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1-г заасан хамтын ажиллагааны хүрээнд байгуулагдах “Итгэлцлийн үйлчилгээний мастер гэрээ” болон “Мэдээлэл солилцох гэрээ”-ний гол нөхцөлийг энэхүү тогтоолын хавсралтаар баталж, эдгээр гэрээнүүд болон хавсралтуудад гарын үсэг зурж баталгаажуулах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
3. Энэхүү тогтоолын дагуу байгуулагдсан гэрээгүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээ авах, энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах, хэрэгжилтийг Компанийн ТУЗ-д эргэн тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



ТУЗ-ИЙН ДАРГА

О.БОЛДБААТАР